



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,  
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/343  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл**

Дуурь бүжгийн эрдмийн театрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*В.Н*

Ц.НАРАНЧИМЭГ



## **“Дуурь бүжгийн эрдмийн театрын” 2016 оны санхүүгийн тайлан**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга: Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг:

[naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер:

Я.Самбууням

Утас: 260512

Цахим хаяг:

[sambuunyamyia@audit.gov.mn](mailto:sambuunyamyia@audit.gov.mn)

Аудитор:

Б.Сэржмядаг

Утас: 260512

Цахим хаяг:

[serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)

**ТАБ-ын хаяг:** Үндэсний аудитын  
газар, ЗГ-ын 4-р байр

**Байршил:** Чингэлтэй дүүрэг

**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

**Аудитын код: САГ-2017/313/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: [www.opera-ballet@yahoo.com](http://www.opera-ballet@yahoo.com)

Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663, Цахимхаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: Цахимхаяг: [sambuunyamyia@audit.gov.mn](mailto:sambuunyamyia@audit.gov.mn)



## Агуулга

|       |                                                                                                               |                                     |
|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| 1     | Аудитын гэрчилгээ .....                                                                                       | 3                                   |
| 2     | Аудитын тайлан.....                                                                                           | 4                                   |
| 2.1   | Оршил.....                                                                                                    | 4                                   |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                         | 4                                   |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....                                         | 5                                   |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....                                               | 5                                   |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6                                   |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....                                          | 6                                   |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....                                                     | 7                                   |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....                                                   | 7                                   |
| 2.9   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....                                       | 8                                   |
| 2.9.1 | Санхүүгийн тайлан.....                                                                                        | 8                                   |
| 2.9.2 | Санхүүгийн үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                                      | 8                                   |
| 2.9.3 | Төрийн өмчийн байрыг түрээслэх гэрээний талаар .....                                                          | 9                                   |
| 2.10  | Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                   | 9                                   |
| 2.11  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                         | 9                                   |
| 2.12  | Шилэн дансны мэдээлэл .....                                                                                   | 10                                  |
| 2.13  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....                                                 | 10                                  |
| 2.14  | Саналдүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....                                                                         | 11                                  |
| 3     | Менежментийн захидал .....                                                                                    | 12                                  |
| 3.1   | Санхүүгийн тайлан.....                                                                                        | 13                                  |
| 3.2   | Төрийн өмчийн байрыг түрээслэх гэрээний талаар .....                                                          | 14                                  |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....                                              | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                                                  | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                                                               | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                                                   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4.4   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                                                | <b>Error! Bookmark not defined.</b> |

## 1 Аудитын гэрчилгээ

ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН  
ЗАХИРАЛ Ч.МӨНХЗУЛ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасаны дагуу Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд эцэслэн

баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, хариуцаж хэрэгжүүлэв.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2017 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 19 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурьдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дуурь бүжгийн эрдмийн театрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дуурь бүжгийн эрдмийн театрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Дуурь бүжгийн эрдмийн театрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд “энгийн” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Дуурь бүжгийн эрдмийн театрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “ACOLose” програм хангамж ашиглажээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Дуурь бүжгийн эрдмийн театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 5 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих, шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн байгууллагын хувьд материаллаг байдлын суурийг төсвийн зардлаар тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,146.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 62.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитуудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, санхүү, бүртгэлийн ажилтнууд харьцангуй тогтвор сууришилтай ажиллаж байгаа бөгөөд эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Аудитын явцад Санхүүгийн үр дүн болон Төсвийн гүйцэтгэлийн тайланд 56,748.5 мянган төгрөгийн залруулга хийж, баримтжуулав.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

**Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа  
зөрчилтэй асуудлын нэгтгэл**

(Сая төгрөгөөр)

| № | Буруу илэрхийлэл буюу алдаа<br>зөрчлийг ангилсан байдал | Тоо      | Дүн | Тайлбар |
|---|---------------------------------------------------------|----------|-----|---------|
| 1 | Зөвлөмж болгосон асуудал                                | 2        |     |         |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон                                 |          |     |         |
| 3 | Албан шаардлага өгсөн                                   |          |     |         |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар<br>шилжүүлсэн             |          |     |         |
| 5 | Хууль хяналтын байгууллагад<br>асуудлыг шилжүүлсэн      |          |     |         |
|   | <b>Дүн</b>                                              | <b>2</b> |     |         |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## **2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

Тайлант онд санхүүгийн тайлангаар 3,401.9 мянган төгрөгийн авлага нь билетийн борлуулалт хийдэг менежерүүдийн тооцоо бодолтоор зээлээр хийсэн борлуулалтын авлага, 8706.0 мянган төгрөгийн өртэй гарсан нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн үлдэгдэл байна.

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

### **2.9.1 Санхүүгийн тайлан**

Дуурь бүжгийн эрдмийн театр хуулиар тогтоосон иж бүрдэлгүй, шаардлага хангаагүй (гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулаагүй) санхүүгийн тайлан, тодруулгыг аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардуулсны эцэст засвар хийсэн тайланг 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулан ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр заалт “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **Шийдвэрлэсэн:**

Санхүүгийн тайлан, тодруулгыг хуулийн хугацаанд Төсвийн тухай хуулийн дагуу Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх зөвлөмж өгөх

### **2.9.2 Санхүүгийн үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаанд харилцах дансаар нэр данс зөрүүтэй 56,748.6 мянган төгрөгийн гүйлгээ гарсан байна. Тус театр эдгээр гүйлгээг санхүүгийн үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан нь 2016 оны жилийн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Тухайлбал эдгээр гүйлгээ нь энэ байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болсон бодит орлого, бодит зардал биш тул тайлант хугацааны үр дүн, төсвийн гүйцэтгэлд оруулан тайлагнах нь зохисгүй юм.

#### **Шийдвэрлэсэн:**

Дээрх нэр данс зөрүүтэй гүйлгээг санхүүгийн үр дүн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаас хасах залруулгыг аудитын явцад хийлгэж, санхүүгийн тайланг баталгаажуулав.

### **2.9.3 Төрийн өмчийн байрыг түрээслэх гэрээний талаар**

Дуурь бүжгийн эрдмийн театр өөрийн төв байрны 34,5 ам.метр талбайг цайны газар, буфет ажиллуулах зориулалтаар Бөөлөө Онио ХХК-д ашиглуулах гэрээ байгуулжээ.

Тус гэрээ байгуулах зөвшөөрөл, гэрээний нөхцлийн талаар холбогдох зөвшөөрөл шийдвэрийг холбогдох байгууллагаас албан ёсоор аваагүй байна

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 1.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Төрийн өмчийн хорооноос баталсан холбогдох журам зааврыг баримтлана" гэсэн заалтыг зөрчиж байна

#### **Гаргасан шийдэл:**

Өмнө байгуулсан гэрээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зөвлөмж өгөх

### **2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Анхаарал татахуйц асуудал гараагүй

### **2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дуурь бүжгийн эрдмийн театр өрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2,818.4 сая төгрөгийн төсөв

баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

### Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн товчоо

/Сая төгрөгөөр/

| №          | Үзүүлэлт                                     | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|------------|----------------------------------------------|------------|-----------|------|-------|
| <b>1</b>   | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн            | 2,818.4    | 2,806.5   | 0.4  |       |
| <b>1.1</b> | Урсгал зардал                                | 2,818.4    | 2,806.5   | 0.4  |       |
| <b>1.2</b> | Хөрөнгийн зардал                             |            |           |      |       |
| <b>1.3</b> | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл   |            | 0         |      |       |
| <b>2</b>   | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр               | 2,795.9    | 2,806.4   | -0.4 | -10.5 |
| <b>2.1</b> | Улсын төсвөөс санхүүжих                      | 2,570.9    | 2,580.9   | -6.3 | -10.0 |
| <b>2.2</b> | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих |            |           |      |       |
| <b>2.3</b> | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 225.0      | 225.5     | 0.2  | 0,49  |

Төсөвт зардлыг нийт дүнгээрээ 11,9 сая төгрөг буюу 0,4 хувиар хэмнэсэн нь унаа болон бусад нөхөн олговор зардлыг 25,6 сая, түлш халаалтын зардлыг 13,3 сая, төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал нийт дүнгээрээ 1,9 сая төгрөгөөр хэмнэгдсэн боловч гэрэл цахилгааны зардал 42,8 хувь буюу 12,46 сая төгрөгөөр хэтэрсэн нь анхаарал татаж байна.

Дээрх зардлуудын хэлбэлзэл нь төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүй, урсгал санхүүжилтийг бүрэн хийгээгүйтэй холбоотой байна.

### 2.12 Шилэн дансны мэдээлэл

Дуурь бүжгийн эрдмийн театр Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

#### **2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дуурь бүжгийн эрдмийн театр 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дуурь бүжгийн эрдмийн театр 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дуурь бүжгийн эрдмийн театрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх султалыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

### 3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

#### **Илрүүлэлт**

Дуурь бүжгийн эрдмийн театр хуулиар тогтоосон иж бүрдэлгүй, шаардлага хангаагүй (гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулаагүй) санхүүгийн тайлан, тодруулгыг аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардуулсны эцэст засвар хийсэн тайланг 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр баталгаажуулан ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр заалт “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **Эрсдэл**

Санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдэл зөрчигдөх

#### **Зөвлөмж**

Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх, тайлагнах стандарт шаардлагыг бүрэн хангасан, иж бүрэн тайланг Төсвийн тухай хуулийн хугацаанд эцэслэн баталгаажуулж, Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх

#### **Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

### 3.2 Төрийн өмчийн байрыг түрээслэх гэрээний талаар

#### **Илрүүлэлт**

Дуурь бүжгийн эрдмийн театр өөрийн төв байрны 34,5 ам.метр талбайг цайны газар, буфет ажиллуулах зориулалтаар “Бөөлөө Онио” ХХК-д ашиглуулах гэрээ байгуулжээ.

Тус гэрээ байгуулах зөвшөөрөл, гэрээний нөхцлийн талаар холбогдох зөвшөөрөл шийдвэрийг холбогдох байгууллагаас албан ёсоор аваагүй байна

Энэ нь Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 1.4-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь төрийн өмчийн эд хөрөнгийг бусад байгууллага иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Төрийн өмчийн хорооноос баталсан холбогдох журам зааврыг баримтлана" гэсэн заалтыг зөрчилдөж байна

#### **Эрсдэл**

Төсвийн хөрөнгийг ашиглалт хууль тогтоомжид нийцэхгүй байх

#### **Зөвлөмж**

Өмнө байгуулсан түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох зөвшөөрөл зөвлөмжийг албан ёсоор авч, гэрээний нөхцлийг холбогдох журам зааварт нийцүүлэн шинэчлэн байгуулах

#### **Төсвийн захирагчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                        | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл   |
|-------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                                                          | <b>3,031,087,714.54</b> | <b>3,225,385,732.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                                                                      | <b>423,136,572.69</b>   | <b>468,263,532.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                                                              | 413,705,753.69          | 460,775,396.00          |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                                                                | 413,705,753.69          | 460,775,396.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                                                       | 233,133,132.69          | 229,067,900.00          |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                                                       |                         |                         |
| 1200043     | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих                                                                                  |                         |                         |
| 1200044     | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих                                                                                 |                         |                         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                                                               | 180,572,621.00          | 231,707,496.00          |
| <b>121</b>  | <b>Хөрөнгийн орлого</b>                                                                                         | 9,430,819.00            | 7,488,136.00            |
| 121001      | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого                                            | 9,430,819.00            | 7,488,136.00            |
| 121002      | Өмч хувьчлалын орлого                                                                                           |                         |                         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                                                            | <b>2,607,951,141.85</b> | <b>2,757,122,200.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                                                                  | 2,425,959,700.00        | 2,585,804,200.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                                                               | 2,425,959,700.00        | 2,585,804,200.00        |
| 131002      | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт                                                          |                         |                         |
| 131003      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                                                           |                         |                         |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                              | 181,991,441.85          | 171,318,000.00          |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж                                             | 16,900,000.00           | 2,000,000.00            |
| 131102      | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл |                         |                         |
| 131103      | ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө    | 106,424,000.00          |                         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө      | 33,765,000.00           | 169,318,000.00          |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                    |                         |                         |
| 131106      | Төсвийн урамшуулал                                                                                              | 24,902,441.85           |                         |
| <b>1340</b> | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>                                                             | -                       | -                       |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих                                                                            |                         |                         |
| 134002      | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                                                                       |                         |                         |
| 134003      | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт                                                         |                         |                         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                                                              | <b>2,933,411,470.46</b> | <b>3,059,458,801.98</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                            | <b>2,933,411,470.46</b> | <b>3,059,458,801.98</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                          | 2,852,560,174.21        | 2,940,653,359.92        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                                        | 2,148,357,200.00        | 2,198,530,787.00        |
| 210101      | Үндсэн цалин                                                                                                    | 1,980,083,300.00        | 2,039,633,387.00        |
| 210102      | Нэмэгдэл                                                                                                        |                         |                         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                                                                           | 168,273,900.00          | 158,897,400.00          |
| 210104      | Урамшуулал                                                                                                      |                         |                         |
| 210105      | Гэрээт ажлын хөлс                                                                                               |                         |                         |
| 210106      | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/                                                                                       |                         |                         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                                                           | 236,231,142.00          | 240,062,172.00          |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                                                              | 152,684,275.00          | 155,478,457.00          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                                                              | 11,510,702.00           | 11,696,831.00           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                                                               | 21,421,046.00           | 22,034,570.00           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                                                            | 9,727,809.00            | 10,138,275.00           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                                                           | 40,887,310.00           | 40,714,039.00           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                                                                | 57,702,806.81           | 89,533,968.00           |
| 210301      | Гэрэл, цахилгаан                                                                                                | 31,252,263.00           | 41,563,399.00           |
| 210302      | Түлш, халаалт                                                                                                   | 23,982,658.00           | 44,132,430.00           |
| 210303      | Цэвэр, бохир ус                                                                                                 | 2,467,885.81            | 3,838,139.00            |
| 210304      | Байрны түрээс                                                                                                   |                         |                         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                         | 21,490,563.30           | 24,508,159.64           |
| 210401      | Бичиг хэрэг                                                                                                     | 1,376,396.00            | 810,815.00              |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                                                                | 2,076,800.00            | 2,120,200.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                                                              | 4,096,879.78            | 4,815,655.14            |
| 210404      | Ном, хэвлэл                                                                                                     | 417,900.00              |                         |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                                                       | 1,692,730.00            | 1,161,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                     | 5,845,025.00            | 5,461,457.50            |
| 210407      | Аж ахуйн материал худалдан авах зардал                                                                          |                         |                         |
| 210408      | Бараа материал акталсны зардал                                                                                  | 5,984,832.52            | 10,139,032.00           |

|        |                                                                                       |                |                |
|--------|---------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|
| 2105   | Нормативт зардал                                                                      | 28,930,397.00  | 23,994,115.40  |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                                       |                |                |
| 210502 | Хоол, хүнс                                                                            |                |                |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                                           | 28,930,397.00  | 23,994,115.40  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                                                     | 6,632,674.00   | 8,795,900.00   |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                                               |                | 1,593,800.00   |
| 210602 | Тавилга                                                                               |                |                |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                                                          |                |                |
| 210604 | Урсгал засвар                                                                         | 6,632,674.00   | 7,202,100.00   |
| 2107   | Томилолт, зочны зардал                                                                | 17,262,089.00  | 19,212,900.00  |
| 210701 | Гадаад албан томилолт                                                                 | 14,035,014.00  |                |
| 210702 | Дотоод албан томилолт                                                                 | 727,075.00     | 9,212,900.00   |
| 210703 | Зочин төлөөлөгч хүдээн авах                                                           | 2,500,000.00   | 10,000,000.00  |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                              | 187,861,813.60 | 184,688,225.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 176,071,821.60 | 169,509,923.60 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                              | 1,022,500.00   | 1,500,000.00   |
| 210803 | Даатгалын үйлчилгээ                                                                   | 589,600.00     | 2,643,120.00   |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар                                                            | 180,500.00     | 187,000.00     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                                         | 10,000.00      | 20,000.00      |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                       | 9,465,200.00   | 10,305,990.00  |
| 210807 | Газрын төлбөр                                                                         | 522,192.00     | 522,192.00     |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                                       | 148,091,488.50 | 151,327,132.28 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                                       |                |                |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                     | 400,000.00     |                |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                                    | 147,691,488.50 | 151,327,132.28 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал                                                           |                |                |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                                      | 80,851,296.25  | 118,805,442.06 |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                                                | 80,846,500.00  | 113,940,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                                                  |                |                |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж                                                  |                |                |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                                        | 17,432,000.00  | 85,320,000.00  |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                                              |                |                |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт                                         |                |                |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 27,908,500.00  | 28,620,000.00  |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг |                |                |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                               | 35,506,000.00  |                |
| 2133   | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг                                           | 4,796.25       | 4,865,442.06   |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                                     |                |                |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө                                             |                |                |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                                 | 4,796.25       | 4,865,442.06   |
| 213304 | Хөрөнгийн                                                                             |                |                |
| 3      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)                                                    | 97,676,244.08  | 165,926,930.02 |
| 145    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН                                                       | -              | -              |
| 225    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                                                       | -              | 2,323,521.84   |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                                        |                | 2,323,521.84   |
| 4      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)                                              | -              | (2,323,521.84) |
| 5      | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)                                                               | 97,676,244.08  | 163,603,408.18 |

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт                                      | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|------------|--------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                         | <b><u>425,052,701.20</u></b>   | <b><u>697,655,714.50</u></b>   |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                                  | -                              | -                              |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>                                          | -                              | 3,401,960.00                   |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                        |                                | 3,401,960.00                   |
| 33200      | Төлбөртэй үйлчилгээний авлага                          |                                |                                |
